



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 165. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг товлон зарлах тухай | Дугаар 25 | 626 |
| 166. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай | Дугаар 26 | 626 |
| 167. | Дахин санал хураалтын зардлын хэмжээг батлах тухай | Дугаар 27 | 627 |
| 168. | Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2013 оны төсвийн тухай | Дугаар 28 | 628 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 169. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 45 | 628 |
| 170. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 46 | 629 |
| 171. | Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 47 | 629 |
| 172. | Зарим шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай | Дугаар 48 | 630 |
| 173. | Зарим шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай | Дугаар 49 | 631 |
| 174. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 50 | 631 |
| 175. | Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 51 | 632 |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

176. | Жагсаалтад өөрчлөлт
оруулах тухай

Дугаар 90 632

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит
сонгуулийг товлон зарлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн товлон зарласугай.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалтыг 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3.Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний саналыг 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс 16-ны өдрүүдэд авахаар тогтоосугай.

4.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит
сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын дээд хэмжээг 15 846 846 804 /арван таван тэрбум найман зуун дөчин зургаан сая найман зуун дөчин зургаан мянга найман зуун дөрөв/ төгрөгөөр тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Дахин санал хураалтын зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, 10.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрогт явагдах дахин санал хураалтын зардлын дээд хэмжээг 397 473 328 /гурван зуун ерэн долоон сая дөрвөн зуун далан гурван мянга гурван зуун хорин найм/ төгрөг байхаар тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны төсөвт зардлаас санхүүжүүлэхийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга /Ч.Содномцэрэн/-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2013 оны төсвийн тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2013 оны төсөв”-ийг хавсралтаар баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилдох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Сан Марино Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шижээхүүгийн Одонбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырийн Сайрааныг эгүүлэн татаж, Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Энхбатыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Батаагийн Батцэрэн, Баттогоогийн Цогт, Готовдоржийн Цагаанцоож, Дамдины Ганзориг, Дашдоржийн Мөнхтуяа, Дашхүүгийн Цолмон, Мишигийн Батсуурь, Хуушааны Эрдэнэсүвд нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

Хоёр. Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Батаагийн Батцэрэнг Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний, Баттогоогийн Цогтыг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Готовдоржийн Цагаанцоожийг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Дамдины Ганзоригийг Нийслэлийн



Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Мишигийн Батсуурийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Хуушааны Эрдэнэсүвдэг Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Зарим шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Довчисэнгээгийн Алтанжигүүрийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Давагийн Алтантуяаг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Чойндонгийн Даваасүрэнг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Бүдрагчаагийн Отгонбямбыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Балдангомбын Хишигдавааг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Цэрэндашийн Цэрэндуламыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Төмөртоогоогийн Энхжаргалыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Зарим шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэгмидийн Дайрийжавыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Лхамхүүгийн Баатарыг Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Арвинбуянгийн Энхбаатарыг Дорнод аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Зоригтын Тунгалагмааг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

Хоёр. Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Арвинбуянгийн Энхбаатарыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Сундуйхүүгийн Энхболд нь гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон тул шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын 2013 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-аас хавсралтад заасан төсөл, арга хэмжээг хассугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2013 оны 90 дүгээр
 тогтоолын хавсралт

 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН
 2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
 ЖАГСААЛТААС ХАСАГДАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2013 онд санхүүжих
			эхлэх	дуусах		
	ХҮII	ХУУЛЬ ЗҮЙН САЙД				
1	ХҮII.1.1.3	Дотоодын цэргийн 805-р ангийн усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын албаны контор, цэргийн гал зүүхны нэгдсэн байр (Улаанбаатар, Баянзүрх)	2013	2013	1,700.0	1,700.0
2	ХҮII.1.1.4	Дотоодын цэргийн бэлтгэл хүчний болон 809-р тусгай салбарын нэгдсэн барилга (Улаанбаатар, Баянзүрх)	2013	2013	1,197.8	1,197.8
3	ХҮII.1.1.5	Мөрдөн байцаах газрын барилга (Улаанбаатар, Чингэлтэй)	2013	2014	7,563.0	3,000.0
	XXI	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД				
4	XXI.1.48	Шинэ Яармагийн орон сууцны хорооллын цэвэр усны насос станц, усан сан, гүний хүдгийн гадна цахилгаан дамжуулах агаарын 10кВ шугам татах (Улаанбаатар, Хан-Уул)	2013	2013	1,500.0	1,500.0
5	XXI.1.49	Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор болон Багануурын үйлдвэрлэл-технологийн паркын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2013	2013	1,000.0	1,000.0
6	XXI.1.53	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц (Улаанбаатар)	2013	2013	5,000.0	5,000.0
7	XXI.1.60	Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголлын дагуу бүсчлэл, инженер геологи, газар хөдлөлийн мужлалын нарийвчилсан зураг төсөл боловсруулах	2013	2014	2,500.0	1,000.0

8	XXI.1.66	Газрын тос боловсруулах үйлдвэрийн гол дэд бүтэц (Дархан)	2013	2013	3,000.0	3,000.0	3,000.0
9	XXI.1.70	Булганхантай хорооллын дэд бүтэц, ажлыг эхлүүлэх, 240 айлын орон сууцны цэвэр, бохир усны хангамж (Архангай)	2013	2013	3,000.0	3,000.0	1,500.0
10	XXI.1.71	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох (Архангай)	2013	2013	4,000.0	4,000.0	2,000.0
11	XXI.1.78	Бохирын 980м ф500 мм-ийн 12АБ коллекторын өргөтгөл (Улаанбаатар, Сансарын туннэлээс зүүн 4 замын уулзвар хүртэл)	2013	2013	924.0	924.0	924.0
12	XXI.1.83	Түрээсийн 396 айлын орон сууц, гадна инженерийн шугам сүлжээний хамт (Улаанбаатар, Чингэлтэй, 10-р хороо 150 айлын орон сууц* 2, Баянгол, 20-р хороо 96 айлын орон сууц)	2013	2013	23,947.0	23,947.0	5,000.0
13	XXI.1.84	"Залуус хороолол"-ын дэд бүтэц (Дорнод)	2013	2013	1,219.8	1,219.8	1,219.8
14	XXI.1.85	Шархад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах ариутгах татуургын шугам сүлжээ (Улаанбаатар, Баянзүрх)	2013	2013	2,013.0	2,013.0	1,000.0
15	XXI.1.86	8, 9, 10, 11-р хорооны нутаг дэвсгэрт баригдах Денжийн-1000 хорооллын ус хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээ (Улаанбаатар, Чингэлтэй)	2013	2013	3,123.1	3,123.1	1,123.1
16	XXI.1.87	Гэр хорооллын инженерийн шугам, сүлжээ (Хөвсгөл, Мөрөн)	2013	2013	5,000.0	5,000.0	1,000.0
17	XXIII.1.1.30	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	2010	2010	15,000.0	15,000.0	4,000.0
18	XXIII.1.1.32	Их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө оруулалт Их сургуулиудын хотхоны дэд бүтэц (Улаанбаатар, Багануур)	2013	2013	2,000.0	2,000.0	2,000.0
19	XXIII.1.1.216	Сургууль, цэцэрлэгийн гадна бохирын байгууламж (Улаанбаатар)	2013	2013	3,500.0	3,500.0	3,500.0
20	XXIII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж	2013	2013	16,700.0	16,700.0	16,700.0

21	XXIII.1.3.2	Малчдын хүүхдийг гэр цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ	2013	2015	4,448.0	1,448.0
22	XXIII.3.1	Боловсрол, шинжлэх ухааны салбарын ТЭЗҮ, зураг, төсөл	2013	2013	3,910.0	3,910.0
	XXVI	ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД				
23	XXVI.1.3.1	Салбарын тоног төхөөрөмж	2013	2013	1,000.0	1,000.0
24	XXVI.2.3.1	Хүүхдийн байгууллагуудын тоног төхөөрөмж	2013	2013	500.0	500.0
	XXVII	ХӨДӨЛМӨРИЙН САЙД				
25	XXVII.3.2.3	Компьютер, тоног төхөөрөмж	2013	2013	3,000.0	3,000.0
	XXVIII	ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД				
26	XXVIII.1.3	Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах (Бүх аймагт)	2011	2015	26,584.0	7,000.0
27	XXVIII.1.6	Түүхий эд, бүтээгдэхүүний бирж байгуулах, түүхий эдийн агуулах байгуулах (Улаанбаатар, бүх аймгуудад)	2012	2013	5,000.0	5,000.0
28	XXVIII.1.8	Хилийн боомтуудад ариутгал халдваргүйтгэлийн байгууламж байгуулах (Монгол мал үндэсний хөтөлбөр)	2012	2017	29,000.0	3,800.0
29	XXVIII.1.11	Аймгийн ХХААЖД-ийн газрын барилга (Сүхбаатар, Баруун-Урт)	2013	2013	890.0	890.0
30	XXVIII.3.1	Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтлийн арга хэмжээг хэрэгжүүлэх өвчтэй малыг халдвар дамжуулахгүйгээр нядлах тоног төхөөрөмж (Монгол мал үндэсний хөтөлбөр)	2011	2013	1,200.0	1,200.0
31	XXVIII.4.5	Таримал ургамлын элит үр үржүүлэг, шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар хангамжийг сайжруулах	2013	2013	3,000.0	3,000.0
	XXXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА				
32	XXXI.1.1	Аймгийн шүүхийн албан конторын барилга шинээр барих (Дархан-Уул, Дархан)	2013	2013	1,268.3	1,268.3



33	XXXI.1.3	Шүүгчдийн албан тушаалын орон сууц	2013	2013	2,043.0	2,043.0
34	XXXI.1.4	Шүүхийн барилга (Улаанбаатар, Баянзүрх)	2013	2013	7,500.0	7,500.0
35	XXXI.1.5	Шүүхийн барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан)	2013	2013	7,500.0	7,500.0
36	XXXI.3	ТЭЗҮ, зураг төсөл			495.7	495.7
	XXXII	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ				
37	XXXII.1.1	Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн барилга (Улаанбаатар, Хан-Уул)	2013	2014	10,000.0	5,000.0
38	XXXII.4	ТЭЗҮ, зураг төсөл			180.0	180.0

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003